



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ХАРЪЯА ХАНГАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
АНГИЙН ЗАХИРАГЧ С.БЯМБАСҮРЭН
ТАНАА

2017. 02. 24 № 3/384
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Онцгой байдлын ерөнхий газрын харъяа Хангамж үйлчилгээний ангийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Онцгой байдлын ерөнхий газрын харъяа Хангамж үйлчилгээний ангийн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем, тэгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэлийг бүрдүүдсэн болно.

Зөрчилгүй санал дүгнэлт

Онцгой байдлын ерөнхий газрын харъяа Хангамж үйлчилгээний ангийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2017\0224\SAG62.Docx

УХА0122

070552



ОБЕГ-ЫН ХАРЬЯА ХАНГАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АНГИ 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дар:
хаягаар харилцана уу:**

Аудитын тайлан

Үндэсний аудитын газар:

ТАБ-ын Тэргүүлэх аудитор,
САГ-ын дарга: Ц.Наранчимэг
Утас: 261663

Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 260512

Аудитор: Ж.Болормаа
Утас: 261628

Үндэсний аудитын газар,
“Засгийн газрын IV байр”, УБ-46
Бага тойруу-6, Улаанбаатар хот,
Монгол Улс
Вэб: www.mnao.pmis.gov.mn

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Гэрээгээр аудит гүйцэтгэсэн:

“Оюу-Эрдэм Аудит” ХХК

Захирал: Н.Цацрал
Утас: 94493362, 99101171

Е-мэйл:
oyuerdem_audit@mongol.net
Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг,
4-р хороо, “Түшиг” төв, 504 тоот

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллаг байдлын түвшин
6. Дотоод хяналт
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Монгол улсын төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалт, мөн хуулийн 18.5 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “ОБЕГ-ын харьяа Хангалт үйлчилгээний анги” ТБАГУТУГ-ын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд САГ/2017/50/СТА-ТШЗ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын Олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“ОБЕГ-ын харьяа Хангалт үйлчилгээний анги” ТБАГУТУГ-ын төсвийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт/УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, Сангийн яамнаас зөвшөөрөл авсан НББ-ийн програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“ОБЕГ-ын харьяа Хангалт үйлчилгээний анги” ТБАГУТУГ-ын төсвийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 13-наас 2017 оны 02 дугаар сарын 23-ныг хүртэл хийхээр төлөвлөн хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Оюу Эрдэм Аудит ХХК нь “ОБЕГ-ын харьяа Хангалт үйлчилгээний анги” ТБАГУТУГ -ын төсвийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан болон дагалдах тайлан судалгаануудыг 2017 оны 02 дугаар сарын 24-нд Үндэсний аудитын газарт хүргүүлэв.

Үндэсний аудитын газар аудитыг 2017 оны 02 дугаар сарын 24-ноос 2017 оны 02 дугаар сарын 25-ний хооронд хянаж, аудитын тайланг 2017 оны 02 дугаар сарын 25-нд байгууллагын удирдлагад гардуулна.

2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

“ОБЕГ-ын харьяа Хангалт үйлчилгээний анги” ТБАГУТУГ-ын төсвийн захирагч нь Монгол Улсын “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”-хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

“Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Хангалт үйлчилгээний анги” ТБАГУТУГ-ын үндсэн үйл ажиллагааны чиглэл нь Онцгой байдлын ерөнхий газрын хэмжээнд нийтлэг үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа юм.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “Агентлагийн дарга тус агентлагийн төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу тус ангийн захирагч Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Байгууллагын 2016 оны төсвийг Сангийн яамны төрийн сангаас олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн барим бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Байгууллагын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Төсвийн захирагчийн төсвийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй, голлох нөлөө бүхий, эрсдэлтэй байж болох томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын горим, нарийвчилсан сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Хангалт, үйлчилгээний ангийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулан, баталж мөрдөөгүй байна.

Төсвийн захирагчид ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Төсвийн захирагчийн санхүүгийн тайлангийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах, бэлтгэхдээ Сангийн яамны тусгай зөвшөөрөлтэй “Acolous” санхүүгийн программаар санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу гаргасан байна.

5. Материаллаг байдлын түвшин

Төлөвлөлтийн үе шатанд нийт цэвэр хөрөнгийг материаллаг байдлын суурь болгон авч, түүний 1,0 хувиар тооцон материаллаг байдлын хэмжээг 17,777.4 мянган төгрөгөөр тогтоосон ба аудитын гүйцэтгэлийн үе шатанд энэ дүнг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн. /ТАБ-СТА-А-4/

6. Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа оршин байгаа эсэхийг нягтлах үүднээс дотоод хяналтын үйл явцыг ажиглан, асуулга авч, шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Төлөвлөлтийн үед Хангалт үйлчилгээний ангийн НББ-ийн дотоод хяналтын эрсдлийг бага гэж тооцсон ба дахин хянаж үзээд дотоод хяналтын үйл ажиллагаа хэвийн гэж үзлээ.

7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2016 оны батлагдсан төсвийг хуваарийн дагуу салбарын яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилт, орлогын гүйцэтгэлийг хангах, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж тайлагнахад удирдлагаас зохих хяналт тавин ажилласан байна.

Төсвийн захирагч нь 2016 онд улсын төсвөөс 1,516,852.6 мянган төгрөгийн санхүүжилт авахаас 1,514,852.6 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авсан. Нэмэлт санхүүжилтээр 185,533.5 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 166,279.1 мянган төгрөгийн хөрөнгө нийт 1,866,665.1 мянган төгрөгийн орлого хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

Төсвийн гүйцэтгэлийн тайланд урсгал зардалд нийт 1,514,852.8 мянган төгрөг зарцуулахаас 1,512,764.0 мянган төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 2,088.8 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

8. Шилэн дансны мэдээлэл

“Шилэн дансны тухай хууль”-ийн дагуу төрийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах, төсвийн санхүүжилт, зарцуулалт, удирдлагын шийдвэр, үйл ажиллагааг ил тод, нээлттэй, ойлгомжтой байлгах, түүнд олон нийт хяналт тавих нөхцлийг бүрдүүлэх ажил хэрэгжилтийг шалгаж үзэхэд “ОБЕГ-ын Харьяа Хангалт үйлчилгээний анги” ТБАГУТҮГ нь хуулийн дагуу нийтэд танилцуулах мэдээллүүдийг интернэтэд байршуулж, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий худалдан авалтын гүйлгээг оруулсан байна.

9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

ОБЕГ-ын харьяа Хангалт үйлчилгээний ангийн үндсэн үйл ажиллагаа, хөрөнгө болон төсвийн зарцуулалтад холбогдох уламжлалт эрсдлийг бага гэж үнэлсэн бөгөөд үндсэн хөрөнгийн эзэмшигчийн эрх зүйн бичиг баримт, зардлын дансдын эдийн засгийн ангилалд холбогдох эрсдэл байна.

Аудитын батламж мэдэгдлүүд, шалгууруудын хүрээнд голлох нөлөө бүхий данс үзүүлэлтүүдэд төлөвлөгөөний дагуу аудитын 8 эрсдлийг тогтоож, гүйцэтгэлийн шатанд нийт 18 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэж, шаардлагатай гэж үзсэн үйл явдал, дансны гүйлгээг давтан гүйцэтгэх горимоор нягтлан шалгав.

10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар

“ОБЕГ-ын Харьяа Хангалт үйлчилгээний анги” ТБАГГУТУГ-ын төсвийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа материал, зардлын дансдын ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 12 сарын 15-ны өдрийн 161-р тогтоолоор “ОБЕГ-ын Харьяа Хангалт Үйлчилгээний анги”-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нэг бүр нь 43,000.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 3 ширхэг ашиглагдаагүй байсан БМП (байлдааны хуягт танк) болон тус бүр 86,533.3 мянган төгрөгийн анхны өртөгтэй 8,653.3 мянган төгрөгийн элэгдэл бүхий 4 ширхэг галын туслах албаны машиныг балансаас балансад шилжүүлэхээр данснаас хассанаар нийт 440,894.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн гарзыг бүртгэсэн.

11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитын явцад илэрсэн зүйлүүд, аудитаар хөндөгдсөн гол асуудлууд ба тэдгээрийг шийдвэрлэсэн байдлыг хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний алдаа илрээгүй бөгөөд материаллаг бус алдаа, зөрчлөөс дурьдвал:

1. Байгууллага 2016 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн тайлангаар хувь хүмүүсээс авах авлага 286.2 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 заалтад дурьдсан “төсвийг зохистой удирдан авлага, өр төлбөр үүсгэхгүй байна” гэсэн заалтыг зөрчиж байна. Мөн эдгээр хүмүүс одоогоор тус байгууллагад ажиллахгүй байгаа тул эргэн төлөгдөх магадлал муутай байна.

Шийдвэрлэсэн: Авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулах, цаашид авлагыг бүрэн барагдуулж, тайлант хугацааны эцэст авлагын үлдэгдэлгүй байх, авлагын үлдэгдлийг баталгаажуулж, авлагыг барагдуулах талаарх зөвлөмжийг менежментийн захидлаар хүргүүлэв.

2. Байгууллага 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд авто тээврийн хэрэгслийн элэгдлийн зардлыг 34,613.3 мянган төгрөгөөр дутуу байгуулсан байна.

Шийдвэрлэсэн: Дутуу байгуулсан 34,613.3 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг тайлант хугацааны санхүүгийн тайланд залруулав.

3. 2016 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн тайлангаар байгууллагын хөрөнгөнд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 2,192,123.7 мянган төгрөгийн хөрөнгө байна. Элэгдлээ нөхсөн хөрөнгө үрэгдэх эрсдэл үүсэх боломжтой байдаг.

Шийдвэрлэсэн: Дээрх өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийн талаар эрх бүхий удирдах дээд байгууллагын удирдлагад танилцуулж, цаашид ашиглагдах боломжтой хөрөнгийг дахин үнэлүүлж, бүртгэн, элэгдлийг тооцох, цаашид ашиглах боломжгүй хөрөнгийг данснаас хасуулах талаар санал оруулж, шийдвэрлүүлэх зөвлөмжийг менежментийн захидлаар хүргүүлэв.

4. Байгууллага 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр хувь хүмүүст өгөх өглөг 86.2 мянган төгрөгийн үлдэгдэлд тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Энэ нь төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 заалтад дурьдсан “төсвийг зохистой удирдан авлага, өр төлбөр үүсгэхгүй байна” гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн: Өглөгийг бүрэн барагдуулах, цаашид тайлант хугацааны эцэст өргүй байх, өглөгийн үлдэгдэл байгаа нөхцөлд үлдэгдлийг баталгаажуулж байх талаарх зөвлөмжийг менежментийн захидлаар хүргүүлэв.

5. Байгууллагын 2016 оны жилийн эцсийн тооллогоор тус байгууллагад бодитой оршин байхгүй “Гаргууд” ХХК-ний тендерээр дутуу нийлүүлэгдсэн 2,000.0 мянган төгрөгийн өртөгтэй 1 ком гагнуурын аппарат, 15,000.0 мянган төгрөгийн өртөгтэй 1 ком автомашины тэнхлэг тохируулагч болон Зэвсэгт хүчний 013 дугаар ангид шилжүүлэн өгсөн 7,236.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 7,236.0 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 1 ширхэг ЗИЛ-131 загварын автомашин буюу нийт 24,236.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нь тус байгууллагын данс бүртгэлд бодитой байгаагаар бүртгэгдсэн байна.

Шийдвэрлэсэн: “Гаргууд” ХХК-аас дутуу нийлүүлэгдсэн 17,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж болон Зэвсэгт хүчний 013 дугаар ангид өгсөн ЗИЛ-131 загварын автомашиныг эргүүлэн бодитоор хүлээн авснаа баталгаажуулахыг менежментийн захидлаар хүргүүлэв.

6. Тус байгууллага нь тайлант хугацаанд 399,9 мянган төгрөгийн өртөгтэй принтер, 339,0 мянган төгрөгийн өртөгтэй сандал нийт 738,9 мянган төгрөгийн хөрөнгийн төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоолгүй худалдан авсан байна.

Шийдвэрлэсэн: Үндсэн хөрөнгө худалдан авахдаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын журмын дагуу зөвшөөрөл авч, худалдан авалт хийж байхыг менежментийн захидлаар хүргүүлэв.

7. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 12 сарын 15-ны өдрийн 161-р тогтоолоор “ОБЕГ-ын Харьяа Хангалт Үйлчилгээний анги”-д бүртгэлтэй 17,950.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 17,950.0 хуримтлагдсан элэгдэлтэй Прадо 95 маркийн 59-15 ДГА улсын дугаартай автомашиныг Дорноговь аймгийн Онцгой байдлын газарт, 13,500.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 13,500.0 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй УАЗ-220 69 маркийн 45-96 УБН улсын дугаартай шуурхай ажлын автомашиныг Хан-Уул дүүргийн Онцгой байдлын газарт, нийт 2 ширхэг 31,450.0 мянган төгрөгийн автомашиныг балансаас балансад шилжүүлэх тогтоол гарсан боловч шилжүүлэн өгөөгүй байна.

Шийдвэрлэсэн: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 12 сарын 15-ны өдрийн 161-р тогтоолыг үндэслэн шилжүүлэн өгөөгүй байгаа автомашинуудыг шилжүүлэн өгч бүртгэлээс хасаж, уг тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг менежментийн захидлаар хүргүүлэв.

8. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 12 сарын 15-ны өдрийн 161-р тогтоолоор “ОБЕГ-ын Харьяа Хангалт Үйлчилгээний анги”-д бүртгэлгүй нийт 5,542,309.8 мянган төгрөгийн анхны өртөгтэй 71 ширхэг автомашиныг аймгуудын Онцгой байдлын газарт балансаас балансад шилжүүлэх тогтоол гарсан. ОБЕГ-ын харьяа хангалт үйлчилгээ газрын тайлбарт тус хөрөнгүүд нь Онцгой Байдлын Ерөнхий Газарт бүртгэлтэй байсан бөгөөд зохих аймгуудын Онцгой байдлын газрууд луу дээрхи хөрөнгүүдийг ОБЕГ-ын харьяа хангалт үйлчилгээний ангиар дамжилгүй шууд шилжүүлсэн байна.

Шийдвэрлэсэн: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоолд хөрөнгө харьяалагдах объектын нэр хаягийн үнэн зөв, бодит эсэхэд хяналт тавьж ажиллах шаардлагатай байна. /ОБЕГ-ын Харьяа Хангалт үйлчилгээний ангиас ирүүлсэн тайлбарыг хавсаргав./

Аудитын явцад илэрсэн зөрчил дутагдлуудыг аудитын асуудлын бүртгэлд тусган байгууллагын удирдлагатай хэлэлцэн тохиролцож, эрсдэл ба аудиторын саналыг менежментийн захидлаар өгөх зөвлөмжид тусгахаар шийдвэрлэв. Илрүүлсэн зөрчлүүдээс шийдвэрлэхэд хүндрэлтэй зүйл байгаагүй бөгөөд шийдвэрлэлгүй үлдээсэн асуудал байхгүй болно.

12. Материаллаг бүс залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Хангалт үйлчилгээний ангийн 2016 оны нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд материаллаг дүн бүхий буруу илэрхийлэл гараагүй учир залруулагдаагүй алдаа үлдээгүй болно.

13. Анхаарал татахуйц бүсэд чухал асуудал

Үндсэн хөрөнгө, бараа материалын тооллого бодитой оршин байгаа эсэхэд хяналт тавих.

14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

"ОБЕГ-ын Харьяа Хангалт үйлчилгээний анги" ТБАГУТУГ-ын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Төсвийн захирагчийн төсвийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын явцад нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналт, авлага, өглөг, үндсэн хөрөнгө, зардлын дансдын бүртгэл, тайлагналын ажилтай холбоотой алдаа, зөрчил, сул талуудыг байгууллагын удирдлагад танилцуулж, мэдэгдсэнээр шийдвэрлэсэн болно. Аудитаар илэрсэн нийт 91,410.63 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн бөгөөд үүнээс 34,613.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 56,797.3 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч ажиллаа.

16.

17. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

"ОБЕГ-ын Харьяа Хангалт үйлчилгээний анги" ТБАГУТУГ-ын төсвийн 2015 оны санхүүгийн тайланд манай компани аудит хийж гүйцэтгэсэн ба бид аудитаар 3 зөвлөмж өгсөн бөгөөд эдгээр зөвлөмжийн 50 хувийг хэрэгжүүлж, биелэлтийг гарган ирүүлсэн байна.

18. Зөрчилгүй, санал дүгнэлт

Төсвийн захирагчийн төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 19 хуудас, хавсралтууд 4 хуудас, байгууллагын санал 2 хуудсыг тус тус хавсаргав.



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ОБЕГ-ЫН ХАРЬЯА ХАНГАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АНГИЙН ТӨСВИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1: Үндсэн хөрөнгийн тооллогын талаар

Асуудал 2: Үндсэн хөрөнгийн худалдан авалтын талаар

Асуудал 3: Үндсэн хөрөнгийн бусад асуудлууд

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 1: Авлага, өглөгийн талаар

2017 он

Менежментийн захидал

Бид аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Төсвийн шууд захирагчид зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Төсвийн захирагчийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ҮАГ-ын ажиглалт

Байгууллагын 2016 оны жилийн эцсийн тооллогоор тус байгууллагад бодитой оршин байхгүй “Гаргууд” ХХК-ний тендерээр дутуу нийлүүлэгдсэн 2,000.0 мянган төгрөгийн өртөгтэй 1 ком гагнуурын аппарат, 15,000.0 мянган төгрөгийн өртөгтэй 1 ком автомашины тэнхлэг тохируулагч болон Зэвсэгт хүчний 013 дугаар ангид шилжүүлэн өгсөн 7,236.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 7,236.0 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 1 ширхэг ЗИЛ-131 загварын автомашин нийт 24,236.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нь тус байгууллагад бүртгэлтэй боловч бодитой оршин байхгүй байна.

Эрсдэлүүд

НББ-ийн тухай хууль, Төсвийн талаарх хууль эрхийн акт зөрчигдөх; Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх;

ҮАГ-ын зөвлөмж

“Гаргууд” ХХК-аас дутуу нийлүүлэгдсэн 17,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж болон Зэвсэгт хүчний 013 дугаар ангид өгсөн ЗИЛ-131 загварын автомашиныг эргүүлэн бодитоор хүлээн авах,

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

ҮАГ-ын ажиглалт

Тус байгууллага нь тайлант хугацаанд 399,9 мянган төгрөгийн өртөгтэй принтер, 339,0 мянган төгрөгийн өртөгтэй сандал нийт 738,9 мянган төгрөгийн хөрөнгийн төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоолгүй худалдан авсан байна.

Эрсдэлүүд

НББ-ийн тухай хууль, Төсвийн талаарх хууль эрхийн акт зөрчигдөх;

ҮАГ-ын зөвлөмж

Үндсэн хөрөнгө худалдан авахдаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зөвшөөрлөөр худалдан авах,

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

1. УАГ-ын ажиглалт

2016 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн тайлангаар байгууллагын хөрөнгөнд элэгдлээрээ анхны өртөгөө нөхсөн нийт 2,192,123.7 мянган төгрөгийн хөрөнгүүд байна.

Эрсдэлүүд

НББ-ийн тухай хууль, Төсвийн талаарх хууль эрхийн акт зөрчигдөх;

2. УАГ-ын ажиглалт

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 12 сарын 15-ны өдрийн 161-р тогтоолоор “ОБЕГ-ын Харьяа Хангалт Үйлчилгээний анги”-д бүртгэлтэй 17,950.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 17,950.0 хуримтлагдсан элэгдэлтэй Прадо 95 маркийн 59-15 ДГА улсын дугаартай автомашиныг Дорноговь аймгийн Онцгой байдлын газарт, 13,500.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 13,500.0 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй УАЗ-220 69 маркийн 45-96 УБН улсын дугаартай шуурхай ажлын автомашиныг Хан-Уул дүүргийн Онцгой байдлын газарт, нийт 2 ширхэг 31,450.0 мянган төгрөгийн автомашиныг балансаас балансад шилжүүлэх тогтоол гарсан боловч шилжүүлэн өгөөгүй байна.

Эрсдэлүүд

НББ-ийн тухай хууль, Төсвийн талаарх хууль эрхийн акт зөрчигдөх;

УАГ-ын зөвлөмж

Дээрх өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийн талаар эрх бүхий удирдах дээд байгууллагын удирдлагад танилцуулж, цаашид ашиглагдах боломжтой хөрөнгийг дахин үнэлүүлж, бүртгэн, элэгдлийг тооцох, цаашид ашиглах боломжгүй хөрөнгийг данснаас хасуулах,

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

УАГ-ын зөвлөмж

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 12 сарын 15-ны өдрийн 161-р тогтоолыг үндэслэн шилжүүлэн өгөөгүй байгаа автомашинуудыг шилжүүлэн өгч бүртгэлээс хасах,

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

3. *ҮАГ-ын ажиглалт*

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 12 сарын 15-ны өдрийн 161-р тогтоолоор “ОБЕГ-ын Харьяа Хангалт Үйлчилгээний анги”-д бүртгэлгүй нийт 5,542,309.8 мянган төгрөгийн анхны өртөгтэй 71 ширхэг автомашиныг аймгуудын Онцгой байдлын газарт балансаас балансад шилжүүлэх тогтоол гарсан. ОБЕГ-ын харьяа хангалт үйлчилгээ газрын тайлбарт тус хөрөнгүүд нь Онцгой Байдлын Ерөнхий Газарт бүртгэлтэй байсан бөгөөд зохих аймгуудын Онцгой байдлын газрууд луу дээрхи хөрөнгүүдийг ОБЕГ-ын харьяа хангалт үйлчилгээний ангиар дамжилгүй шууд шилжүүлсэн байна.

Эрсдэлүүд

НББ-ийн тухай хууль, Төсвийн талаарх хууль эрхийн акт зөрчигдөх;

ҮАГ-ын зөвлөмж

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоолд хөрөнгө харьяалагдах объектын нэр хаягийн үнэн зөв, бодит эсэхэд хяналт тавьж ажиллах,

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Асуудал 1: Авлага, өглөгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

Байгууллага 2016 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн тайлангаар хувь хүмүүсээс авах авлага 286.2 мянган төгрөгийн авлага, хувь хүмүүст өгөх өглөг 86.2 мянган төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Мөн эдгээр хүмүүс одоогоор тус байгууллагад ажиллахгүй байгаа тул авлага эргэн төлөгдөх магадлалгүй байна.

Эрсдэлүүд

НББ-ийн тухай хууль, Төсвийн тухай хууль зөрчигдөх;

ҮАГ-ын зөвлөмж

Авлага, өглөгийг барагдуулах ажлыг шуурхай зохион байгуулах, цаашид авлага, өглөг үүсгэхгүй байх,

Энэ нь төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 заалтад дурьдсан “төсвийг зохистой удирдан авлага, өр төлбөр үүсгэхгүй байна” гэсэн заалтыг зөрчиж байна.

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

ОБЕГ-ЫН ХАРЬЯА ХАНГАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АНГИЙН
2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН ТАЙЛАН

/ төгрөгөөр/		
Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
Кассанд байгаа бэлэн мөнгө		-
Банк дахь харилцах данс		-
АВЛАГА	324,405.01	261,230.29
Бусад авлага	324,405.01	261,230.29
УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ	3,838,450.26	8,333,030.05
Урьдчилж гарсан зардал	3,838,450.26	8,333,030.05
БАРАА МАТЕРИАЛ	412,782,069.25	229,312,711.47
Бэлэн бүтээгдэхүүн	141,778,559.60	-
Түүхий эд материал	33,814,550.00	19,026,100.00
Хангамжийн материал	237,188,959.65	210,286,611.47
Бусад		
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	416,944,924.52	237,906,971.81
ҮНДСЭН ХӨРӨНГӨ		
Биет хөрөнгө		
Барилга, байгууламж, орон сууц	2,046,024,258.00	2,046,024,258.00
Барилга, байгууламж, орон сууц (Хуримтлагдсан элэгдэл)	(1,625,594,089.56)	(1,647,551,121.72)
Авто-тээврийн хэрэгсэл	4,056,120,537.87	3,738,627,204.55
Авто-тээврийн хэрэгсэл (Хуримтлагдсан элэгдэл)	(2,297,698,241.07)	(2,729,020,981.38)
Машин тоног төхөөрөмж	77,714,525.48	63,068,855.48
Машин тоног төхөөрөмж (Хуримтлагдсан элэгдэл)	(68,655,665.20)	(57,613,821.75)
Тавилга, аж ахуйн эд хогшил	32,850,203.02	30,464,125.43
Тавилга, аж ахуйн эд хогшил (Хуримтлагдсан элэгдэл)	(20,537,540.72)	(20,862,083.64)
Батлан хамгаалахын зориулалттай тоног төхөөрөмж	510,090,843.30	381,090,843.30
Батлан хамгаалахын зориулалттай тоног төхөөрөмж (Хуримтлагдсан)	(277,174,176.61)	(298,674,176.65)
Бусад үндсэн хөрөнгө	1,633,707.90	1,633,707.90
Бусад үндсэн хөрөнгө (Хуримтлагдсан элэгдэл)	(1,633,707.90)	(1,633,707.90)
Биет бус хөрөнгө		
Програм хангамж	1,829,050.00	1,829,050.00
Програм хангамж	(1,469,831.25)	(1,696,706.25)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,433,499,873.26	1,505,685,445.37
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,850,444,797.78	1,743,592,417.18
ӨР ТӨЛБӨР		
Ажилчидтай холбогдсон тооцоо	-	-
Бараа үйлчилгээний зардлын тооцоо	48,094.00	375,800.00
Бусад өглөг	3,130,276.85	86,167.00
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	3,178,370.85	461,967.00
Засгийн газрын оруулсан капитал	3,177,929,954.05	3,177,929,954.05
Өмнөх үеийн үр дүн	(1,104,748,865.18)	(1,104,734,628.52)
Тайлант үеийн үр дүн	-	(1,104,135,976.75)
Дахин үнэлгээний зөрүү	774,085,338.06	774,071,101.40
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН	2,847,266,426.93	1,743,130,450.18
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН	2,850,444,797.78	1,743,592,417.18

ОБЕГ-ЫН ХАРЪЯА ХАНГАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
АНГИЙН
2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТ ХИЙСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

		/ төгрөгөөр/
ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		
УЛСЫН ТӨСВӨӨС	1,768,231,520.31	1,700,386,051.00
Урсгал	1,462,909,600.00	1,514,852,600.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,462,909,600.00	1,514,852,600.00
Хөрөнгийн орлого	-	-
Нэмэлт санхүүжилтийн орлого	305,321,920.31	185,533,451.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан доод	6,720,000.00	-
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны	297,654,000.00	-
Төсвийн урамшуулал	947,920.31	-
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд	-	185,533,451.00
Бараа, үйлчилгээний орлого	1,194,945,147.16	166,279,065.10
Үндсэн үйл ажиллагааны орлого	-	-
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	-	-
Үнэ төлбөргүй хүлээн авсан	890,160,164.66	166,279,065.10
Шинээр олголт	304,784,982.50	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,963,176,667.47	1,866,665,116.10
АЖИЛЛАГСАДТАЙ ХОЛБООТОЙ ЗАРДАЛ	1,190,005,572.04	1,261,614,726.87
Үндсэн болон нэмэгдэл цалин	1,145,555,500.08	1,214,245,899.54
Үндсэн цалин	951,378,748.08	936,309,273.81
Нэмэгдэл цалин	14,912,040.00	-
Унаа, болон бусад нөхөн олговор	69,645,600.00	78,471,000.00
Гэрээтийн цалин	109,619,112.00	199,465,625.73
Нийгмийн хамгааллын шимтгэл	44,450,071.96	47,368,827.33
Тэтгэврийн даатгалын шимтгэл	17,275,488.65	18,439,310.54
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,974,038.34	2,099,684.66
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,452,867.66	2,583,264.19
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	450,443.28	469,588.33
Эрүүл мэндийн даатгалын хураамж	22,297,234.03	23,776,979.60
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ	1,422,217,000.89	1,266,101,481.40
Бараа үйлчилгээний тогтмол зардал	60,194,545.00	45,923,697.58
Гэрэл цахилгаан	35,550,720.00	25,019,200.00
Түлш, халаалт	24,643,825.00	20,260,987.58
Цэвэр, бохир ус	-	643,510.00
Хангамжийн материалын зардал	155,027,074.27	170,385,886.66
Бичиг хэргийн зардал	2,366,190.00	4,092,000.00
Тээвэр, шатахууны зардал	150,385,485.39	163,023,172.61
Шуудан, харилцаа холбооны зардал	2,275,398.88	3,270,714.05
Нормативт зардал	2,592,700.00	197,768,799.70
Эм, вакцин	283,100.00	706,000.00
Хоол хүнс	2,309,600.00	2,483,320.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл худалдан авах зардал	-	194,579,479.70
Эд хогшил, урсгал засварын зардал	342,331,239.00	233,214,495.02
Багаж хэрэгсэл	773,730.00	164,900.00
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	259,250,876.00	83,293,438.00
Жижиг эд хогшил худалдан авах	-	-
Урсгал засвар	82,306,633.00	149,756,157.02
Томилолтын зардал	10,575,000.00	11,234,200.00
Дотоод томилолтын зардал	10,575,000.00	11,234,200.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	169,193,633.74	72,269,605.50
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил	133,330,760.00	36,850,930.00
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	2,000,000.00	2,000,000.00
Даатгалын үйлчилгээний төлбөр	28,995,903.74	26,160,325.50
Төлбөр хураамж, жижиг татварууд	-	-
Тээврийн хэрэгслийн татвар	3,459,470.00	3,458,350.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	1,407,500.00	3,800,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	682,302,808.88	535,304,796.94
Бусад зардал	143,620,000.00	39,551,477.79
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	951,400.00	650,000.00

Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	537,731,408.88	495,103,319.15
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,871,020.81	2,190,430.84
Засгийн газрын урсгал шилжүүлэг	9,263,320.81	2,190,430.84
Төвлөрүүлэн шилжүүлэх	9,263,320.81	2,190,430.84
Бусад урсгал шилжүүлэг	3,607,700.00	-
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,607,700.00	-
Хөрөнгийн санхүүжилт /төсөвт байгууллагад/	-	-
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДАЛЫН ДҮН	2,625,093,593.74	2,529,906,639.11
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	338,083,073.73	(663,241,523.01)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	51,638,690.38	440,894,453.74
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	286,444,383.35	(1,104,135,976.75)

ОБЕГ-ЫН ХАРЬЯА ХАНГАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АНГИЙН
2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН ТАЙЛАН

/ төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2014 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	3,177,929,954.05	780,233,738.06	(1,397,341,648.53)	2,560,822,043.58
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			6,148,400.00	6,148,400.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,177,929,954.05	780,233,738.06	(1,391,193,248.53)	2,566,970,443.58
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт		(6,148,400.00)		(6,148,400.00)
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
Тайлант үеийн үр дүн			286,444,383.35	286,444,383.35
2015 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	3,177,929,954.05	774,085,338.06	-1,104,748,865.18	2,847,266,426.93
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			14,236.66	14,236.66
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,177,929,954.05	774,085,338.06	(1,104,734,628.52)	2,847,280,663.59
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт		(14,236.66)		(14,236.66)
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
Тайлант үеийн үр дүн			(1,104,135,976.75)	(1,104,135,976.75)
2016 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	3,177,929,954.05	774,071,101.40	-2,208,870,605.27	1,743,130,450.18

ОБЕГ-ЫН ХАРЪЯА ХАНГАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АНГИЙН
2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/ төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,768,231,520.31	1,700,386,051.00
Засгийн газрын бусад түвшнээс авах тусламж санхүүжилт		
Улсын төсвөөс	1,462,909,600.00	1,514,852,600.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,462,909,600.00	1,514,852,600.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	305,321,920.31	185,533,451.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан доод шатны	6,720,000.00	-
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны	297,654,000.00	-
Төсвийн урамшуулал	947,920.31	-
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд	-	185,533,451.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	195,011,744.42	929,004.95
Бараа, үйлчилгээний орлого	195,011,744.42	929,004.95
Үндсэн үйл ажиллагааны орлого	-	-
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	195,011,744.42	929,004.95
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,963,243,264.73	1,701,315,055.95
АЖИЛЛАГСАДТАЙ ХОЛБООТОЙ ЗАРДАЛ	1,192,902,661.42	1,264,314,047.00
Үндсэн болон нэмэгдэл цалин	1,147,393,461.42	1,221,438,647.00
Үндсэн цалин	853,507,515.80	943,645,621.24
Унаа, болон бусад нөхөн олговор	84,073,702.06	78,327,400.00
Гэрээтийн цалин	209,812,243.56	199,465,625.76
Нийгмийн хамгааллын шимтгэл	45,509,200.00	42,875,400.00
Тэтгэвэрийн даатгалын шимтгэл	15,714,000.00	17,911,530.98
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,815,600.00	2,059,137.82
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	3,640,200.00	2,531,807.29
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,986,700.00	461,865.23
Эрүүл мэндийн даатгалын хураамж	22,352,700.00	19,911,058.68
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ	562,150,138.08	434,071,678.11
Бараа үйлчилгээний тогтмол зардал	55,750,720.00	68,055,400.00
Гэрэл цахилгаан	35,550,720.00	31,456,700.00
Түлш, халаалт	20,200,000.00	34,499,710.00
Цэвэр, бохир ус		2,098,990.00
Хангамжийн материалын зардал	209,301,443.08	176,846,970.85
Бичиг хэргийн зардал	1,678,500.00	2,291,120.00
Тээвэр, шатахууны зардал	205,918,358.20	171,629,082.80
Шуудан, харилцаа холбооны зардал	1,704,584.88	2,926,768.05
Нормативт зардал	2,506,200.00	3,038,100.00
Эм, вакцин	350,000.00	500,000.00
Хоол хүнс	1,410,200.00	1,345,840.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл худалдан авах зардал	746,000.00	1,192,260.00
Эд хогшил, урсгал засварын зардал	43,551,230.00	74,692,625.02
Багаж хэрэгсэл	2,582,480.00	1,062,800.00
Урсгал засвар	40,968,750.00	73,629,825.02

Томилолтын зардал	9,966,000.00	10,858,400.00
Дотоод томилолтын зардал	9,966,000.00	10,858,400.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	29,658,695.00	90,812,465.24
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил	-	58,840,200.00
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,200,000.00	2,000,000.00
Даатгалын үйлчилгээний төлбөр	22,528,025.00	22,713,915.24
Тээврийн хэрэгслийн татвар	3,459,470.00	3,458,350.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	2,471,200.00	3,800,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	211,415,850.00	9,767,717.00
Бараа үйлчилгээний бусад зардал	204,421,750.00	5,801,717.00
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	6,994,100.00	3,966,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	207,852,045.23	2,190,430.84
Засгийн газрын урсгал шилжүүлэг	9,263,320.81	2,190,430.84
Төвлөрүүлэн шилжүүлэх	9,263,320.81	2,190,430.84
Бусад урсгал шилжүүлэг	198,588,724.42	-
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,607,700.00	-
Нэр данс зөрүү төсөл хөтөлбөр зарлага	194,981,024.42	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (II)	1,962,904,844.73	1,700,576,155.95
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	338,420.00	738,900.00
ХӨРӨНГИЙН ОРЛОГО		
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	390,500.00	738,900.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(390,500.00)	(738,900.00)
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(52,080.00)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	52,080.00	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

**ОБЕГ-ЫН ХАРЬЯА ХАНГАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АНГИЙН
2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН	1,516,852,500.00	1,512,764,027.11	4,088,472.89	99.73%
НИЙТ ЗАРДЛЫН ДҮН	1,516,852,500.00	1,512,764,027.11	4,088,472.89	99.7%
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,516,852,500.00	1,512,764,027.11	4,088,472.89	99.7%
Бараа, үйлчилгээний зардал	1,514,852,800.00	1,512,764,027.11	2,088,772.89	99.9%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	1,220,611,300.00	1,220,611,500.00	(200.00)	100.0%
Үндсэн цалин	919,951,300.00	942,818,474.24	(22,867,174.24)	102.5%
Унаа,болон бусад нөхөн олговор	84,845,700.00	78,327,400.00	6,518,300.00	92.3%
Гэрээтийн цалин	215,814,300.00	199,465,625.76	16,348,674.24	92.4%
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх	42,875,700.00	42,875,400.00	300.00	100.0%
Тэтгэврийн даатгал	15,106,700.00	17,911,530.98	(2,804,830.98)	118.6%
Тэтгэмжийн даатгал	1,726,800.00	2,059,137.82	(332,337.82)	119.2%
ҮОМШӨ-ний даатгал	2,157,800.00	2,531,807.29	(374,007.29)	117.3%
Ажилгүйдлийн даатгал	431,900.00	461,865.23	(29,965.23)	106.9%
Байгууллага төлөх ЭМД-ийн хураамж	23,452,500.00	19,911,058.68	3,541,441.32	84.9%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	68,055,400.00	68,055,400.00	-	100.0%
Гэрэл цахилгаан	42,803,600.00	31,456,700.00	11,346,900.00	73.5%
Түлш, халаалт	23,350,000.00	34,499,710.00	(11,149,710.00)	147.8%
Цэвэр, бохир ус	1,901,800.00	2,098,990.00	(197,190.00)	110.4%
Хангамж, бараа материалын зардал	104,798,800.00	104,798,770.85	29.15	100.0%
Бичиг хэргийн зардал	1,668,300.00	2,291,120.00	(622,820.00)	137.3%
Тээвэр, шатахууны зардал	101,166,100.00	99,580,882.80	1,585,217.20	98.4%
Шуудан, харилцаа холбооны зардал	1,964,400.00	2,926,768.05	(962,368.05)	149.0%
Нормативт зардал	3,038,100.00	3,038,100.00	-	100.0%
Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	500,000.00	500,000.00	-	100.0%
Хоол, хүнс	1,552,500.00	1,345,840.00	206,660.00	86.7%
Нормын хувцас зөөлөн эдлэл	985,600.00	1,192,260.00	(206,660.00)	121.0%
Эд хогшил худалдан авах	38,443,400.00	35,803,391.02	2,640,008.98	93.1%
Багаж, техник, хэрэгсэл	3,782,600.00	1,801,700.00	1,980,900.00	47.6%
Урсгал засвар	34,660,800.00	34,001,691.02	659,108.98	98.1%
Томилолт, зочны зардал	1,643,200.00	1,643,200.00	-	100.0%
Дотоод зочны зардал	1,643,200.00	1,643,200.00	-	100.0%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний	31,986,900.00	31,972,265.24	14,634.76	100.0%
Даатгалын үйлчилгээ	22,714,400.00	22,713,915.24	484.76	100.0%
Аудит, баталгаажуулалтзэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00	-	100.0%
Тээврийн хэрэгслийн татвар	3,472,500.00	3,458,350.00	14,150.00	99.6%
Тээврийн хэрэгслийн оношилгоо	3,800,000.00	3,800,000.00	-	100.0%
Бараа үйлчилгээний бусад зардал	3,400,000.00	3,966,000.00	(566,000.00)	116.6%
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,400,000.00	3,966,000.00	(566,000.00)	116.6%
Татаас	1,999,700.00	-	1,999,700.00	0.0%
Бусад урсгал шилжүүлэг	1,999,700.00	-	1,999,700.00	0.0%
Ажил олгогчоос олгох тэтгэмж,	1,999,700.00	-	1,999,700.00	0.0%
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,516,852,600.00	1,512,764,027.11	4,088,572.89	99.7%
Төсвөөс санхүүжих	1,516,852,600.00	1,512,764,027.11	4,088,572.89	99.7%
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		-	-	
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-	-	
БАЙГУУЛЛАГЫН ТОО		-	-	
Ажиллагсад бүгд	123.00	121.00	2.00	98.4%
Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0%
Гүйцэтгэх ажилтан	87.00	85.00	2.00	97.7%
Үйлчлэх ажилтан	35.00	35.00	-	100.0%

ОБЕГ-ЫН ХАРЪЯА ХАНГАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АНГИЙН
2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН	-	-	-	-
НИЙТ ЗАРДЛЫН ДҮН	-	-	-	-
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН			-	-
Бараа, үйлчилгээний зардал	126,693,251.00	126,693,251.00	-	100.0%
Хангамж, бараа материалын зардал	72,048,200.00	72,048,200.00	-	100.0%
Тээвэр, шатахууны зардал	72,048,200.00	72,048,200.00	-	100.0%
Эд хогшил худалдан авах	39,628,134.00	39,628,134.00	-	100.0%
Урсгал засвар	39,628,134.00	39,628,134.00	-	100.0%
Томилолт, зочны зардал	9,215,200.00	9,215,200.00	-	100.0%
Дотоод албан томилолт	9,215,200.00	9,215,200.00	-	100.0%
Бараа үйлчилгээний бусад зардал	5,801,717.00	5,801,717.00	-	100.0%
Бараа үйлчилгээний бусад зардал	5,801,717.00	5,801,717.00	-	100.0%
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	185,533,451.00	185,533,451.00	-	100.0%
Төсвөөс санхүүжих	185,533,451.00	185,533,451.00	-	100.0%
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
Ажиллагсад бүгд	121.00	121.00	-	100.0%
Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0%
Гүйцэтгэх ажилтан	85.00	85.00	-	100.0%
Үйлчлэх ажилтан	35.00	35.00	-	100.0%